

Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн
ажиллах заавар батлах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 22 дугаар зүйлийн 22.4, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн ажиллах заавар”-ыг нэгдүгээр, “Дуудлага худалдааны ялагчтай байгуулах гэрээний загвар”-ыг хоёрдугаар, “Төсөл сонгон шалгаруулалтын ялагчтай байгуулах гэрээний загвар”-ыг гуравдугаар, Төсөл сонгон шалгаруулах төсөл хүлээн авсан тухай тодорхойлолтыг /СШ-1/ дөрөвдүгээр, Төсөл хүлээн авсан маягтыг /СШ-2/ тавдугаар, Сонгон шалгаруулалтанд ирүүлсэн төслийн нээлтийн тэмдэглэлийг /СШ-3/ зургадугаар, Сонгон шалгаруулах төсөл дүгнэх маягтыг /СШ-4/ долдугаар, Сонгон шалгаруулалтанд оролцсон оролцогчдын үнэлгээний нэгдсэн онооны маягтыг /СШ-5/ наймдугаар, Сонгон шалгаруулалтанд оролцох оролцогчдын бүртгэлийн маягтыг /СШ-6/ есдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү заавар батлагдсантай холбогдуулан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2015 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Комиссын ажиллах журам батлах тухай” А/22 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн Ажлын албаны дарга /Б.Чулуун-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БААСАНДОРЖ